



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 9/01

Тавин

Статистикийн мэдээ тайлан гаргах ажилтан томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 66 дугаар зүйлийн 66.1, Статистикийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3.3, 15 дугаар зүйлийн 15.1.1, 18 дугаар зүйл, 21 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Статистикийн мэдээ тайланг холбогдох үйлдвэрлэлийн болон бусад чиглэлийн дагуу нэгтгэж гаргах албан тушаалтан, хариуцлагатай ажилтнуудыг хавсралтаар баталсугай.

2. Статистикийн батлагдсан мэдээ тайланг заагдсан хугацааны дотор мэдээ тайланг хариуцсан ажилтан болон холбогдох газар, хэлтэст нь гаргаж өгөхийг статистикийн мэдээ тайлан хариуцсан ажилтнуудад даалгасугай.

3. Хавсралтад заагдсан мэдээ тайланг тухайн батлагдсан хуваарийн дагуу хугацаанд нь өгч, тасалдал, хожимдол гаргахгүй байхыг аж ахуйн нэгжийн захирал, байгууллагын дарга, эрхлэгч, хувийн хэвшлийн эздэд даалгасугай.

4. Статистикийн мэдээ тайлан хариуцсан ажилтнуудаас ирүүлсэн тайлан мэдээг нэгтгэн цаг хугацаанд нь хожимдуулахгүй мэдээлж ажиллахыг Хөдөө аж ахуйн тасгийн дарга (Э.Нандинцэцэг), Бугант тосгоны Төрийн сангийн мэргэжилтэн (Т.Туул) нарт үүрэг болгосугай.



Б. СЭРГЭЛЭН